

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ӨВӨРМӨЦ ҮЗҮҮЛЭЛТИЙН 2025 ОНЫ БИЕЛЭЛТ**

2026 оны 01 дүгээр сарын 12-ний өдөр

№	Шалгуур үзүүлэлт	2024 он	2025 он	Тайлбар
1	Нийт ажилчдын тоо	110	100	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолоор төрийн албаны шинэчлэлийг хийж, төрийн албан хаагчдын тоог үе шаттайгаар бууруулж, төрийн албыг “тооноос чанарт” шилжүүлж, цомхон, чадварлаг, бүтээмжтэй болгохоор заасан. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголтой уялдуулан төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиас доошгүйгээр бууруулах чиглэлийг Засгийн газраас өгснийг үндэслэн ЗӨСҮТ нь 10 орон тоог цөөлөн, цалингийн сангаас хассантай холбогдуулан төвийн орон тооноос 10 орон тоог цөөлсөн
2	Хүний нөөцийн хангалтын хувь	90%	92%	2024 онд 110 орон тоотой ажилласнаас 98 ажилтны бүрэлдэхүүнтэй, 2025 онд 100 орон тоонд 92 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
3	Эмнэлгийн мэргэжилтний хангалтын хувь	100%	100%	Зоонозын өвчин судлал болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн мэргэжилтний хангалтыг бүрэн хангасан.
4	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшсэн байдал /мэргэжил эзэмшсэн/	100%	100%	Эмч, мэргэжилтнүүд Зоонозын өвчин судлал үндсэн мэргэжлийн сургалт, магистрийн хөтөлбөр, Талбарын тархвар судлал, Мэргэжил дээшлүүлэх сургалтуудад бүрэн хамрагдсан.
5	Эрдмийн цол, мэргэжлийн зэрэг хамгаалсан мэргэжилтэн: /их эмч, дунд мэргэжилтэн тус бүрийн тоо/	2	2	Энэ онд тархвар судлагч Н.Саруулчулуун “Талбарын тархвар судлал” жилийн сургалт, Халдвар судлагч Н.Отгонбаяр “Зоонозын өвчин судлал” үндсэн мэргэжлийн сургалтуудад тус тус хамрагдаж төгссөн. Энэ онд магистрын хөтөлбөрт шинээр хамрагдсан 1, суралцаж байгаа нийт магистрантур 7, доктрантурт 6 эмч, мэргэжилтэн тус тус суралцаж байна.
6	Тасралтгүй сургалтын кредитын шаардлага хангасан эмчийн хувь	5 эмч, мэргэжилтэн 100%	12 эмч, мэргэжилтэн 10%	2024 он: 6 эмч эмчлэх эрхийн лицензтэй бөгөөд үүнээс 5 эмч 2024 онд багц цагийн сургалтууд болон дүйцүүлэх сургалт, материалаар кредитийн шаардлага хангасан байна.

				2025 он: Төвийн хэмжээнд 12 эмч, мэргэжилтэн лицензтэй байгаагаас 8 эмч, 3 эмч зүйч, 1 сувилагч ажиллаж байна. Энэ онд 1 эмч багц цагийн сургалт болон дүйцүүлэх сургалт, материалаар кредитийн шаардлага хангасан байна. Бусад эмч, мэргэжилтнүүдийн хувьд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 2026-2028 онд дуусахаар байна.
7	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь	98,3%	96,4	2024 онд төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгыг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд 6 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж, төлөвлөгөө биелэлт 98.3 хувьтай хэрэгжсэн байна. 2025 онд төвийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд 10 зорилт 57 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж, төлөвлөгөө биелэлт. 96,4 хувьтай хэрэгжсэн байна. Дүгнэлт: Өмнөх онуудад хийх гүйцэтгэсэн үйл ажиллагааны чиглэл, зорилтыг, тусламж үйлчилгээний стандарт, чанар сайжруулах мөн стратегийн зорилтод түвшинд хүрэхэд чиглэгдсэн олон талт хамтын үйл ажиллагааг бодлогын түвшинд уялдуулан хийж гүйцэтгэсэн.
8	Байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь	92%	94%	2024 он: Байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийг ЭНЭҮТ-2 эмнэлэгтэй хамтран зохион байгуулж нийт 82 албан хаагч буюу 92 хувь нь хамрагдсан. Үүнээс: ✓ Элэгний үйл ажиллагааны өөрчлөлттэй -/23/-28 % ✓ Бөөр шээсний замын үрэвсэл /7/-8% ✓ Цөсний үйл ажиллагаа өөрчлөлттэй хүн /15/-18% ✓ Өөх тосны солилцооны алдагдалтай хүн /18/-21% ✓ Нойр булчирхайн үрэвсэл, өөрчлөлттэй /21/-25% ✓ Бамбайн үйл ажиллагааны өөрчлөлттэй /5/-6% ✓ Улаан хоолой, ходоодны дуран ✓ Улаан хоолой, ходоодны дуранд 29 албан хаагч хамрагдсан. Үүнээс: ✓ Эрүүл-5

				✓ Улаан хоолойн сөргөө -/7 /-24% ✓ Улаан хоолойн мөөгөнцөр-/1/-3% ✓ Ходооднын архаг үрэвсэл-/9/-31% ✓ Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн 75 хувь нь хөх, Элэгний хавдрын эрт илрүүлээгийн хүрээнд В С вирус илрүүлэг хэвлийн эход ажилчдын 90 хувь хамрагдаж В вирусийн архаг халдвартай-3,С вирусийн архаг халдвартай-2 албан хаагч байгаа бөгөөд эмчилгээнд хамрагдсан хяналтад байдаг. ✓ бамбайн эхо,умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд орсноос хавдарт сэжиглэгдэх өөрчлөлт илрээгүй. ✓ Бүдүүн шулуун гэдэсний хавдрын эрт илрүүлэг оношилгоонд өтгөнд далд цус илрүүлэх сорилоор зорилтот насны 16 албан хаагч хамрагдсан бүгд сөрөг дүнтэй. ✓ Артерийн даралт хэвийн-75% ✓ Артерийн даралт ихсэлт-25% ✓ БЖИ ✓ Хэвийн –43% ✓ Илүүдэл жинтэй -33% ✓ Таргалалт -16% ✓ Хэт таргалалт -6% ✓ ЧШЭ-ийн оноо 5 ба түүнээс дээш -3% ✓ Үзлэг дүгнэлтийг үндэслэн хүн бүрд тохирсон зөвлөгөө зөвлөмж өгч дараагийн шатлалд үзүүлэх, эрүүлжүүлэх ,хуваарь гарган ажиллаж байна мөн "Артерийн даралт ихсэх эмгэг болон Чихрийн шижин хэв шинж 2" өвчин сэдвээр сургалт хийв. 2025 он: 2025 он: Байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгийг улсын хоёр дугаар төв эмнэлгийн дэмжих төв болон Рехамед эмнэлэгтэй хамтран зохион байгуулж хамрагдвал зохих 89 албан хаагчаас нийт 84 албан хаагч буюу 94 хувь нь хамрагдсан. 5 албан хаагч тухайн жилд өөр эмнэлэгт оношилгоо шинжилгээнд хамрагдсан байна. Энэ удаагийн оношлогоо шинжилгээнд 2024 оны урьдчилан сэргийлэх үзлэгийн зарим зүйлд үндэслэн
--	--	--	--	---

					бүртгэгдсэн байна. Өмнөх оноос -9 буюу 150 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
		Хачигт боррелиоз /A69/	1	1	2024, 2025 онуудад хачигт боррелиозын хүний өвчлөл тус бүр 1, тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх оны түвшинд байна. Хачигт боррелиозын өмнөх оноос өссөн бууралт ажиглагдсангүй. Өмнөх оны түвшинд байна.
		Хачигт риккетсиоз /A77/	93	68	2024 онд хачигт риккетсиозын хүний өвчлөлийн 93 тохиолдол, 2025 онд 68 тохиолдол бүртгэгдсэн байна. Хүний өвчлөлийн тохиолдол-25 буюу өмнөх оноос 36,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
		Галзуу /A82/	0	0	2024 болон 2025 онуудад галзуугийн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.
		Хумхаа /B50/	6	6	Зөөвөрлөгдөх халдвар болох хумхаа өвчин 2024 онд 6 тохиолдол 2025 онд 6 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Өмнөх оноос өссөн, буурсан дүр зураг ажиглагдахгүй байна.
		Бруцеллөз /A23	37	55	Улсын хэмжээнд 2024 онд Бруцеллөзын хүний өвчлөлийн 37 тохиолдол, 2025 онд 55 тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх оноос +18 ихэссэн буюу 32,7 хувиар өссөн дүнтэй байна.
		Бэтэг /B67/	5	5	2024 болон 2025 онд хүний бэтэг өвчний тус бүр 5 тохиолдол бүртгэгдсэн. Өмнөх оноос өссөн, буурсан үзүүлэлт ажиглагдаагүй ижил түвшинд байна
		Streptococcus suis	0	1	2025 онд Streptococcus suis халдварын 1 удаагын тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь тус халдварын Монгол улсад бүртгэгдсэн анхны тохиолдол болсон.
		Ям /A24/	0	0	2024 болон 2025 онуудад ям өвчний хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.
11	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох,	Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшлээр	3	3	2024 онд Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшлийн сургалтад 3 мэргэжилтэн суралцаж төгссөн 3ӨСҮТ-өөс 1,

	мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагдагсдын тоо				Баянхонгор аймгийн ЗӨСТ-өөс 1, Өмнөговь аймгийн ЗӨСТ-өөс 1 мэргэжилтэн тус тус төгссөн. 2025 онд Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшлийн сургалтад 3 мэргэжилтэн суралцаж төгссөн. ЗӨСҮТ-өөс 1 мэргэжилтэн, Дундговь, Хөвсгөл аймгийн ЗӨСТ-өөс тус бүр 1 мэргэжилтэн суралцаж төгссөн.
		Ариутгал судлал төрөлжсөн мэргэшлээр	7	3	2024 онд Тус төвөөс Ариутгал судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтад 7 мэргэжилтэн сурацлаж төгссөн. 2025 онд Ариутгал судлалын мэргэшлийн сургалтад үндэсний төвөөс 3 мэргэжилтэн суралцаж төгссөн.
		Биологичийн мэргэжил дээшлүүлэх сургалт	0	8	2025 онд Биологичийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг 1 удаа зохион байгуулж, 8 мэргэжилтэн хамруулсан. Тус сургалтад Баянхонгор, Баян-Өлгий, Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн нийт 8 биологич хамрагдсан.
		Ажлын байрны дагалдан сургалт	18	18	2024 онд 14 удаа зохион байгуулж мөн 18 мэргэжилтэн хамруулсан. 2025 онд Ажлын байрны дагалдан сургалтыг 4 удаа зохион байгуулж 18 мэргэжилтэн хамруулсан.
12	Судалгаа, эрдэм шинжилгээний хүлээлгэн өгсөн тайлан		0	0	2025 онд хүлээлгэн өгсөн судалгааны тайлан байхгүй.
13	Хэвлэгдсэн сэтгүүл болон хэвлэл		1	3	2024 онд онд Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүлийн 1 дугаар хэвлэгдэж байсан. 2025 онд Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүлийн 1 дугаар, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын 2 эмхэтгэл хэвлэгдсэн бол
14	Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо		2	1	2024 онд тус төвөөс 2 мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн ухааны магистр зэрэг хамгаалсан бол 2025 онд 1 нян судлагч шинээр анагаах ухааны магистрын зэрэг хамгаалсан.
15	Идэвхтэй тандалтаар шинээр илрүүлсэн голомтын тоо		9	4	2024 онд Хачгаар дамжих халдварт өвчний тандалтаар 9 сумын нутагт хачигт риккетсиозын үүсгэгчийг хачигнаас илрүүлж голомтыг тогтоосон. 2024 оноос харъяа ЗӨСТөвүүд лабораторийн шинжилгээг орон нутагтаа хийж байгаа.

				2025 онд Төв аймгийн 3 сумын 4 цэгт хачгаар дамжих халдварын цэгийг тогтоосон. Газар зүйн мэдээллийн санд оруулсан.
16	Тухайн жилд төлөвлөгдсөн тандалтын гүйцэтгэлийн хувь	14/100%	9/100%	2024 онд Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 14 тандалт судалгааг хийж ЗӨСҮТ-ийн удирдлагын зөвлөлөөр тандалт хийсэн мэргэжилтнүүд нийт тандалтын үр дүнг хэлэлцүүлэн дүгнүүлсэн. 2025 онд Хийгдэх 9 тандалт судлагаа төлөвлөгдсөнөөс ОХУ-тай хамтрасан -2, БНХАУ-тай хамтарсан-2, Хэнтий аймгийн ЗӨСТ-тэй хамтран -1, УМЭАЦТЛ-1, ХАБҮЛЛ-1 тандалт судалгаа хийж гүйцэтгэсэн байна. Дүгнэлт: Байгалийн идэвхитэй голомтыг тогтоох тандалт судалгаа болон хүн ам зүйд чиглэгдсэн тандалт судалгааны нэр төрөл, Нэг эрүүл мэнд зарчимд тулгуурлан бүс нутгийн болон дотоодын салбар дундын мэргэжлийн байгууллагын оролцооны түвшин нэмэгдсэн үзүүлэлтэй байна.
17	Сэжигтэй тохиолдлын дуудлага	-936 дуудлага	-813 дуудлага	2024 онд Зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй нийт 936 дуудлагыг хүлээн авч хүлээн авч хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллав. Үүнд: 433 (46.3%) галзуугийн сэжигтэй мал амьтанд уруулж ноцуулсан, 364(38.9%) хачигт риккетсиоз, 82(8.8%) хачигт энцефалит, 17 (1.8%) бэтэг, 13(1.4%) хачигт боррелиоз, 9 (1.0%) тарваган тахал, 9(1.0%) хумхаа, 5(0.5%) боом, 3(0.3%) бруцеллөз, 1 токсоплазмоз (0.1%)-ийг эзэлж байна. -Үүнээс 90(24.7%) хачигт риккетсиоз, 16(19.5%) хачигт энцефалит, 3(23%) хачигт боррелиоз, 5(29.4%) бэтэг, 6(66.6%) хумхаа, 3(100%) бруцеллөз өвчний тохиолдол батлагдсан. -Нийт дуудлагаас хачгаар дамжих халдвар 49.8 хувийг, галзуугийн эрсдэлд өртсөн тохиолдол 46.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. 2024 онд токсоплазмоз шинээр нэмэгдсэн. -Үүнээс зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 936 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн, сүүлийн 5 жилийн дундажаас 12.3 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь

				тандалтын мэдээлэл солилцох, мэдээллийн цар хүрээтэй холбоотой. Цаашид галзуу өвчний байгалийн голомт тэлж байгаад дүгнэлт хийж, сэргийлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах, вакцин ийлдсийн хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. 2025 онд зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй нийт 813 дуудлагыг хүлээн авч хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллав. Үүнд: 383 (48.7%) хачигт риккетсиоз, 327 (37.0%) галзуугийн сэжигтэй мал амьтанд уруулж ноцуулсан, 39 (4.8%) хачигт энцефалит, 23 (2.8%) бэтэг, 14 (1.7%) тарваган тахал, 8 (1.0%) хумхаа, 7(0.9%) боом, 5 (0.6%) хачигт боррелиоз, 3 (0.4%) холер, 1 (0.1%) бруцеллёз, 1 (0.1%) гахайн стрептококк, 1 (0.1%) токсоплазмоз, 1 (0.1%) лептоспироз тус тус эзэлж байна. -Үүнээс 73 (73%) хачигт риккетсиоз, 8 (8%) хачигт энцефалит, 1 (1%) хачигт боррелиоз, 6 (6%) хумхаа, 1 (1%) боом, 1 (1%) тарваган тахал, 5 (5%) бэтэг, 1 (1%) гахайн стрептококкок өвчний тохиолдол батлагдсан. Хөвсгөл аймагт тарваган тахлын хүний өвчлөлийн батлагдсан 1 тохиолдол, ЦТЭ-т бэтэг өвчнөөр 1 тохиолдол тус тус нас барсан. Улсын хэмжээнд ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй нийт 807 дуудлагыг хүлээн авсан ба өмнөх оны мөн үеэс 13.2% буурсан, сүүлийн 5 жилийн дундажаас 1.44% хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дуудлага хяналтын 70282853 жижүүрийн утсанд нийт 3739 дуудлага хүлээн авч, албан байгууллага, иргэдэд цаг хугацаа алдалгүй зөвлөгөө, зөвлөмж өгч сар бүрийн дуудлагын багийн мэргэжилтнүүд, удирдлагуудад танилцуулж, халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөц, тусгаарлах байр, шимэгчийн лаборатори, яаралтай дуудлагын оношлогоо, өсгөвөр судалгаанд шаардлагатай амьтдын бэлэн байдлыг ханган хариу арга хэмжээг авч ажиллаа. 1,4,5,6,7,8,9 саруудад утсаар зөвлөгөө, зөвлөмж авах нь илүүтэй бүртгэгдсэн. 2025 онд хачигт халдварын тохиолдол сүүлийн 5 жилийн дундаж болон өмнөх онтой харьцуулахад тогтвортой буурах хандлагатай байна. Нийт батлагдсан тохиолдол
--	--	--	--	---

				2024 онд 109 байсан бол 2025 онд 96 болж, 24.8%-иар буурсан.		
18	Амьтны дуудлагад үйлчилсэн тоо		257	171	2024 онд Төвийн дуудлагын утсанд ирсэн 257 удаагийн дуудлагад үйлчилж 845 мэрэгч хураагдсан. 2025 онд Тус төвд 171 удаагийн дуудлагаар 659 мэрэгч хураагдсан байна. Дууддлага 33.5%-аар, нийт хураагдсан мэрэгч амьтаны тоо 22.0% -аар тус тус буурсан байна.	
19	Эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан хувь (нэр төрлөөр)	Тарваган тахал		18998	0	2024 онд ЭМС-ийн 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд 19 аймгийн 121 сум, Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт тарваган тахлын дархлаажуулалтыг 18998 хүн хамруулсан нь зорилтот бүлгийн 52% хамрагдсан үзүүлэлтэй байсан. 2025 онд Монгол улсын хэмжээнд тарваган тахлын вакцин нийлүүлэгдээгүй.
		Хачигт энцефалит	I тун	1446	2543	2024 онд Хачигт энцефалит өвчний эсрэг дархлаажуулалт 20 аймгийн 59 сум, Нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулагдаж 4484 хүн хамрагдсан. I-р тунгийн хамралт 95.2%, II-р тунгийн хамралт 68.8%, III-р тунгийн хамралт 96.2%, сэргээх тунгийн хамралт 86.3% байна. Хачигт энцефалитын халдвар авсан 16 хүнд эмчилгээний зорилгоор 1509 мл иммуноглобулин тарьсан. 2025 онд Хачигт энцефалитын дархлаажуулалтад 16 аймгийн 50 сум, Нийслэлийн 8 дүүргийн нийт 3833 хүн хамрагдсан. Үүнээс голомтот нутгийн хүн ам 27%, ЭМБ-ын ажилчид 0.7%, Онцгой байдлын албан хаагчид 19.5%-ийг эзэлж байна.
			II тун	1149	1542	
			III тун	455	765	
			Сэргээх	366	309	
		Боом		0	0	2020 оноос хойш боомын дархлаажуулалт хийгдээгүй. Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцөд боомын вакцин захиалсан боловч нийлүүлэгдээгүй байна. Боомын вакцин нь олон давтан тунтай, тариулсны дараа урвал хүндрэл илэрдгээс бүрэн тунгийн хамралт хангалтгүй байдаг.
Галзуу		9587	6459	2024 онд Нийт галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан 9587 хүн галзуугаас сэргийлэх вакцинд хамрагдсан. Үүнээс өндөр эрсдэлтэй 50 хүн иммуноглобулин эмчилгээнд хамрагдсан.		

				2025 онд Галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан 6459 хүн галзуу өвчний эсрэг вакцинд хамрагдсан. Үүнээс өндөр эрсдэлтэй 37 хүн галзуугийн эсрэг иммуноглобулин эмчилгээнд хамрагдсан.
20	Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь	100%	100%	2024 он: Онош тодруулахаар 11 төрлийн зоонозын халдварын сэжигтэй тохиолдолын 588 сорьц хүлээн авч, 6 төрлийн лабораторийн шинжилгээний аргаар шинжилснээс 114 сорьц эерэг дүнтэй, лабораторийн оношийн баталгаажилт 2023 онтой ижил түвшинд буюу 100 % байна. 2025 он: 2025 онд онош тодруулахаар 12 төрлийн зоонозын халдварын сэжигтэй 442 тохиолдолын 608 сорьц хүлээн авч, 6 төрлийн лабораторийн шинжилгээний аргаар шинжилснээс 110 сорьц эерэг дүнтэй, лабораторийн оношийн баталгаажилт 2024 онтой ижил түвшинд буюу 100 % байна.
21	Зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг лабораторийн шинжилгээнд хамруулсан хувь	100%	100%	2024он: Улсын хэмжээнд 11 төрлийн зоонозын гаралтай хүний өвчлөлийн сэжигтэй дуудлагын нийт 588 сорьц хүлээн авч бичил харах, нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн аргаар шинжилж, лабораторийн шинжилгээнд 100% хамруулсан байна. 2025он: Улсын хэмжээнд 12 төрлийн зоонозын гаралтай хүний өвчлөлийн сэжигтэй дуудлагын нийт 608 сорьц хүлээн авч 6 төрлийн лабораторийн шинжилгээний аргаар шинжилж, лабораторийн шинжилгээнд 100% хамруулсан байна. Дүгнэлт: Зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын лабораторийн шинжилгээнд хамрагдалт 2024 онтой ижил түвшинд буюу 100 % байна
22	Эерэг сорьцын баталгаажилт	94.6%	98.8%	2024 он: Лавлагаа лабораторийн албанд сүлжээ 14 ЗӨСТ-ийн лабораториудаас тарваган тахал 6, боом 1, эризепелойд 1 нийт 8 өсгөвөр, хачигт халдварын 11 ийлдэс, байгалийн

				голомтоос илрүүлсэн хачиг 50, эрхтний булинга 5 нийт 74 өсгөвөр, эерэг сорьц хүлээн авч нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн аргаар шинжлэхэд 94.6% батлагдсан. 2025 он: Лавлагаа лабораторийн албанд сүлжээ 14 ЗӨСТ-ийн лабораториудаас тарваган тахал 24, боом 2 нийт 26 өсгөвөр, хачигт халдварын 7 ийлдэс, байгалийн голомтоос илрүүлсэн хачигны булинга 139 , бэтэг 2, хумхаа 1 нийт 177 өсгөвөр, эерэг сорьц хүлээн авч нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн аргаар шинжлэхэд 98.8% нь батлагдсан. Дүгнэлт: Нийт 177 өсгөвөр, эерэг сорьц хүлээн авч нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн аргаар шинжлэхэд 98.8% батлагдаж, эерэг сорьцын баталгаажилт өмнөх оноос 4.2% -иар өссөн үзүүлэлттэй байна.
23	Гадаад чанарын хяналт	100%	100%	2024 он Гадаад чанарын хяналтаар нян судлал, молекул биологийн чиглэлээр нийт 4 удаа хамрагдан “Хангалттай” үнэлгээ авсан. 1. ХАБҮЛЛ - ЗӨСҮТ-ийн “Ур чадварын сорил” хөтөлбөр I-II ээлж, Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдийг II хагас жилийн ур чадварын сорилд 100% хамрагдсан. 2. Тайланд улсын Чулалонгкорн Их сургуулийн Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн нян судлалын ур чадварын сорилд хамрагдсан. 3. УМЭАЦТЛ-той лаборатори хоорондын харьцуулалт <i>Bac.anthraxis</i> хамрагдсан. 2025 он Гадаад чанар хяналтаар нян судлал, молекул биологийн чиглэлээр нийт 3 удаа хамрагдан “Хангалттай” үнэлгээ авсан. 1. Төв болон Зоонозын сүлжээ лаборатори ХАБҮЛЛ-иос зохион байгуулсан ур чадварын I-II ээлжийн сорилд Гэрээний дагуу 2 удаа хамрагдаж <i>Listeria</i>

				<i>monocytogenes, Bacillus cereus, Staphylococcus aureus</i> илрүүлэн “Хангалттай” үнэлгээ авсан. 2. УМЭАЦТЛ-той лаборатори хоорондын харьцуулалтад <i>Bacillus anthracis</i> үүсгэгчээр хамрагдсан. Дүгнэлт 2025 онд Төв болон Нийслэл, аймгийн ЗӨСТ-ийн 14 лаборатори ХАБҮЛЛ-ийн Ур чадварын сорил хөтөлбөрийн I-II ээлжид 100% хамрагдсан. Нийслэл аймгийн ЗӨСТ-ийн лабораторийн эмч мэргэжилтнүүдийн ур чадварын үнэлгээ 2024 онтой харьцуулахад 35.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.
24	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	66,5%	66,9%	2024 он Био-Аюулгүйн 2-р зэргийн кабинет 7ш нэмэгдэж хангамж 100%, химийн бодис хадгалах шүүгээ 3ш нэмэгдсэнээр үзүүлэлт 60% нэмэгдэж нийт хангамжийн хувь өмнөх оныхоос 1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2025 он Хатаах шүүгээ 2ш нэмэгдсэнээр үзүүлэлт 80% нэмэгдэж нийт хангамжийн хувь өмнөх оныхоос 0,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
25	Хэмжих хэрэгслийн баталгаажилт	80%	91,6%	2024 он Нийт 21 багаж хэмжих хэрэгсэл шалгалт тохируулгад хамруулахаас жин 3ш баталгаажих боломжгүй хэмжлийн зөрүү ихтэй гэсэн хариу гарсан учраас баталгаажаагүй. 2025 он Нийт 60 багаж хэмжих хэрэгсэл шалгалт тохируулгад хамруулахаас хөргүүрийн мэдрэгч 4ш, жин 1ш баталгаажих боломжгүй, хэмжлийн зөрүү их гэсэн хариу гарсан учраас баталгаажаагүй.
26	Халдваргүйтгэсэн нэгж материалын тоо	35722	18134	2024 он: Оношзүйн болон ЭЗЧХЛ-ийн судалгаа шинжилгээний ажилд хэрэглэсэн 35722 нэгж материалыг хүлээн авч хими, физикийн аргаар халдваргүйжүүлсэн. 2025 он: 18346 нэгж материалыг хүлээн авч хими, физикийн аргаар халдваргүйжүүлсэн. Дүгнэлт: ЗӨСҮТ-ийн лабораторууд 2025.09.15 эхлэн бүрэн засварт орсонтой холбоотойгоор яаралтай дуудлагын сорьц шинжлэхээс бусад үйл ажиллагаа зогссон. Мөн мэрэгчийг төлбөртэй шинжлэх тухай Төвийн

				захирлын тушаал гарсантай холбоотойгоор шинжилгээнд ирэх хураагдсан тарвагын тоо багассан. Үүнтэй холбоотойгоор халдваргүйтгэх нэгж материалын тоо 1.9 дахин багассан байна.
27	Угаасан шилэн эдлэл, зөөлөн эдлэлийн тоо	48151	31611	2024 он: 48151 ширхэг шилэн эдлэл, зөөлөн эдлэлийг угааж эргэлтэнд оруулсан 2025 он: 31704 ширхэг шилэн эдлэл, зөөлөн эдлэлийг угааж эргэлтэнд оруулсан Дүгнэлт: Лаборатори засварт орсноос шалтгаалан угаасан нэгж материалын тоо 1.5 дахин багассан
28	Ариутгасан нэгж материалын тоо	70882	56722	2024 он: 70882 нэгж материалыг хими, физикийн аргаар ариутгасан 2025 он: 56722 нэгж материалыг хими, физикийн аргаар ариутгасан Дүгнэлт: Автоклавын болон хуурай халууны аргаар ариутгасан нэгж материалын тоо нь 2025 онд 1.2 дахин багассан нь мөн дээрхтэй ижил шалтгаантай
29	Нийт аюултай хог хаягдлын хэмжээ (кг)	5258.8 кг	2853 кг	2024 он: 5258.8 кг аюултай хог хаягдал гарсан 2025 он: 3512.5 Дүгнэлт: Хураагдсан тарвага болон мэрэгч амьтныг төлбөртэй шинжилдэг болсноор шинжилгээнд ирэх мэрэгч амьтны тоо багассан нь 2025 оны аюултай хог хаягдлын хэмжээ 1.5 дахин багасах гол шалтгаан юм
30	Үйлдвэрлэсэн үндсэн тэжээлт орчны хэмжээ (л)	1054.95	957.75	2024 он: 2054.95л үйлдвэрлэсэн 2025 он: 957.7 л үйлдвэрлэсэн. Дүгнэлт: 2025.09.15 эхлэн БҮЛ бүрэн засварт орж үндсэн тэжээлт орчин үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрэн зогссон нь тоон үзүүлэлт өмнөх оноос 9.2%-аар буурхад голлон нөлөөлсөн.
31	Үйлдвэрлэсэн өвөрмөц тэжээлт орчны хэмжээ (л)	327.27л	179.634	2024 он: 327.27л үйлдвэрлэсэн 2025 он: 179.6л үйлдвэрлэсэн Дүгнэлт: ЗӨСҮТ-ийн онош зүйн лабораториуд засварт орж судалгаа, шинжилгээний ажил 3 сарын хугацаанд хийгдээгүйгээс төрөл бүрийн үндсэн тэжээлт орчны хэрэглээ буурсан болон харилцагч хамтрагч байгууллагуудын захиалга бага байсантай холбоотойгоор өвөрмөц тэжээлт орчны үйлдвэрлэл өмнөх оноос 1.8 дахин буухад голлон нөлөөлсөн байна.

32	Үйлдвэрлэсэн будаг урвалж уусмалын хэмжээ (л)	350.44	353.265	2024 он: 350.44л үйлдвэрлэсэн 2025 он: 353.3л үйлдвэрлэсэн Дүгнэлт: Будаг урвалж уусмал үйлдвэрлэлийн хэмжээ 2024 онтой бараг адил түвшинд байгаа нь лаборатори засварт орохтой холбоотойгоор зарим төрлийн өргөн хэрэглээний уусмалыг урьдчилан бэлтгэж нөөцөлсөнтэй холбоотой.
33	Үйлдвэрлэсэн будаг шингээсэн, болон нүүрс ус шингээсэн цаас (ш)	6900	12940	2024 онд зөвхөн будаг шингээсэн цаас үйлдвэрлэсэн, 2025 онд будаг шингээсэн цаас болон нүүрс ус шингээсэн цаасыг аль алинийг нь үйлдвэрлэсэн тул 2025 онд 1.9 дахин өссөн дүнтэй гарсан байна.
34	Үйлдвэрлэсэн оношилгооны нян залгиурын хэмжээ (мл)	810	275	2024 онд 3 төрлийн нян залгиур үйлдвэрлэсэн, 2025 онд зөвхөн тарваган тахлын нян залгиур үйлдвэрлэсэн тул 2.9 дахин бага хэмжээтэй дүн гарсан байна. Учир нь бусад төрлийн нян залгиурын үлдэгдэл хангалттай хэмжээтэй байсан тул төлөвлөгөөнд ороогүй болно.
35	Тохиолдолын тоо	4	8	2024 онд 4 тохиолдол бүртгэгдсэн. 2025 онд 8 тохиолдол бүртгэгдсэн. Дүгнэлт: Тохиолдлын тоо өмнөх оноос өссөн үзүүлттэй байна. Тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдол бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам, хичээлийг ажилтнуудад 2 удаа орсон. Ажилтануудын тохиолдолын тухай мэдлэг нэмэгдсэн тул тохиолдол нэмэгдсэн.
36	Эрсдлийн тоо	0	2	2024 онд эрсдэл бүртгэгдээгүй. 2025 онд 2 эрсдэл бүртгэгдсэн. Тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн эрсдлийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах зааврыг ажилтнуудад танилцуулах сургалт орсон.
38	Ажилтнуудын ерөнхий сэтгэл ханамжийн хувь	78%	95%	2024 онд сэтгэл ханмажийн судалгаагаар ажилтнуудын ерөнхий сэтгэл ханамж 78% байна. 2025 онд Байгууллагын ажилтан, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг албан хаагчдаас санал авч, өгсөн саналын дагуу асуумжийг шинэчлэн боловсруулж 8 бүлэгтэй 37 асуумжаар Google Form ашиглан сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч үр дүнг нэгтгэн удирдлагын зөвлөлд танилцуулдаг. Тухайн

				онд сэтгэл ханамжийн судалгаагаар ажилтануудын ерөнхий сэтгэл ханамж 95% байна.
39	Нэвтрүүлсэн шинэ технологи	1	1	2024 онд Тэжээлт орчин хуурайшуулах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж Үндэсний төв болон салбар төвүүдэд туршилтаар хэрэглүүлэн 1 шинэ технологи нэвтрүүлсэн. 2025 онд дээрх технологийг бүрэн нэвтрүүлж үйлдвэрлэлийн технологийн заавар батлагдсан. Мөн адууны нормаль ийлдэс бэлтгэх технологи-1, B.cereus нянг ялган дүйх зориулалттай МҮР агар бэлтгэх технологи-1 тус тус судлан туршиж нэвтрүүлсэн байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ